



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЪЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

САЙНЦАГААН СУМЫН МАТЕМАТИКИЙН
ГҮНЗГИЙРҮҮЛСЭН СУРГАЛТТАЙ
ДӨРӨВДҮГЭЭР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ С.ОДОНЧИМЭГ ТАНАА

2017.01.16 № 01/01

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 203 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын журам"-ын 1.9, аймгийн Аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Сайнцагаан сумын Математикийн гүнзгийрүүлсэн сургалттай дөрөвдүгээр сургуулийн 2016 оны гуравдугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрын аудитаар **1,410,000.00** /Нэг сая дөрвөн зуун арван мянган/ төгрөгөөр аялал зохион байгуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д /Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/ мөн Засгийн газрын 2015 оны 147 дугаар тогтоолын 6-д /Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр, ялангуяа төсвийн нэмэлт орлого, хандив болон тусламжийн орлогоор гадаад, дотоодын тойрон аялал, зугаалга, ой тэмдэглэх арга хэмжээ, урлагийн наадам, уралдаан тэмцээн зохион байгуулахгүй байх/ заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-д /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Засгийн газрын 2015 оны 147 дугаар тогтоол болон Улсын Их Хурлын 47 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, төсвийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах;

0000000001

2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2017 оны 01 дүгээр сарын 25-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Сайнцагаан сумын Математикийн гүнзгийрүүлсэн сургалттай дөрөвдүгээр сургуулийн захирал /С.Одончимэг/, нягтлан бодогч /П.Мөнгөнцэцэг/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

АУДИТОР  Т.ОЮУН-ЭРДЭНЭ



ЗӨВШӨӨРСӨН:


Сайнцагаан сумын Математикийн гүнзгийрүүлсэн сургалттай дөрөвдүгээр сургуулийн :

ЗАХИРАЛ 

С.ОДОНЧИМЭГ

НЯГТЛАН БОДОГЧ 

П.МӨНГӨНЦЭЦЭГ



¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.